



**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2022 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/88

Улаанбаатар хот

**Сонгон шалгаруулалт
зохион байгуулах тухай**

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/256 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны дүрмийн 3.2.3 дахь заалт, 3.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төвийн Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн Салбар хороог шинээр байгуулах нээлттэй сонгон шалгаруулалтыг зарласугай.
2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн Салбар хорооны гишүүний Сонгон шалгаруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Дарга: Н.Халиун Үйлдвэрлэлийн тасгийн Технологич их эмч

Гишүүн: Б.Солонго Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албаны дарга

Нарийн бичгийн дарга:

Я.Тогтохням Хүний нөөцийн ажилтан, хуулийн зөвлөх

3. Сонгон шалгаруулалтыг холбогдох дүрмийн дагуу зохион байгуулахыг Комиссын дарга /Н.Халиун/, зарыг байгууллагын цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлахыг Нарийн бичгийн дарга /Я.Тогтохням/-д тус тус даалгасугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, маркетингийн албаны дарга /Ч.Батболд/-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР